Бидний судалгааны гол зорилго нь уг талбайн төлөв байдлын өөрчлөлт, төрөл бүрийн нөлөөлөл, чанарын үзүүлэлтүүдийг хууль, тогтоомж, журам, заавар, удирдамжид заагдсан үзүүлэлтүүдээр тогтоон, ашиглалтын газрын нэгж талбарын бүртгэл, зурган болон тоон мэдээлэл бүрдүүлж цаашид ашиглалт, хамгаалалтад төрөөс тавих хяналт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийг зөв оновчтой явуулахад ашиглах суурь материал бүрдүүлэхэд оршино.

Цаашид газрын гадаргуугийн төрх байдал, өөрчлөгдсөн хэмжээг тогтоох, улмаар газрын хөрсний үржил шим, чанар байдал, ургамал нь нөмрөгийн төрх байдал, талхлагдсан эсэх гэх мэт үндсэн үзүүлэлтүүдэд тулгуурлан хянан баталгааны дүгнэлт гаргаж, зөвлөмж өгч, хянан баталгааны сүлжээний зураг үйлдэж, нэгж талбар тус бүрээр паспорт бичиж дүгнэлт гаргах асуудалд чиглэгдэнэ.



БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГАЗҮЙ

3.1. Судалгааны арга зүй

Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг гүйцэтгэхдээ доорх эрх зүйн актуудыг тус ажлын аргачлал, эрх зүйн үндэслэл болгов. Үүнд:

1. Монгол Улсын газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3 дахь заалт;
2. Засгийн газрын 2024 оны 03 дүгээр сарын 06-ны өдрийн 92 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт;
3. Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 02-р сарын 22-ны өдийн 34 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт;

Дээрх тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх ажлыг бэлтгэл ажил, хээрийн судалгаа, материал боловсруулалт гэсэн 3 үе шаттайгаар хийж гүйцэтгэв. Үүнд:

Бэлтгэл ажлын үед: Захиалагчаас өгсөн ажлын даалгавар болон холбогдох аргазүй, заавар, журамтай танилцаж, хянан баталгаа хийгдэх талбайн байр зүйн болон сансрын зураг, хөрс, ургамал, байгаль орчны урьд өмнө нь хийгдсэн судалгаа зэргийг ашиглав.

Мөн хянан баталгааны ажил хийж гүйцэтгэх хээрийн судалгааны шинжээчдийн багийг томилж, тус судалгаагаар хийгдэх ажлын даалгавар, төлөвлөгөө, маршрутыг боловсруулж, судалгаанд шаардлагатай багаж хэрэгсэл, материалуудаа (хээрийн судалгааны ажлын зураг, хөрсний бичиглэлийн маягт, ургамлын бичиглэлийн маягт, тор, гадас, хөрсний дээж авах уут, хүрз, метр, шугам, жин, зөөврийн байрлал тодорхойлох GPS, фото аппарат болон бусад шаардагдах багаж гэх мэт) бэлтгэв. Хянан баталгаа хийх газрын онцлог, байгаль, цаг уур, газар ашиглалтын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийв.

Хээрийн судалгааны үе шат: Судалгаанд хамрагдаж буй талбайн газрын гадаргын төрх (тогтоц), хөрс, ургамлан нөмрөгийн төлөв байдал, өөрчлөлтийг тодорхойлон тогтоох ажлыг доорх аргачлалаар гүйцэтгэв. Үүнд:

- *Газар ашиглалтын судалгаа:* Газар ашиглалтын судалгааг хийхдээ газар ашиглалт олгосон зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх, тухайн эзэмшил газрыг хашаалсан эсэх, хатуу хучилттай болгосон эсэх, хөрсний өнгөн хэсэг тоосорхог болсон эсэх, хог ургамлын тархац ямар байгаа эсэх, физик, хими, биологийн бохирдол байгаа эсэх, хүнд металлын бохирдолтой эсэх, хөрс зулгарсан, гуу жалга үүссэн, өндөр хүчдэл, үер усны аюул байгаа эсэх, хог хаягдал, худаг, усны орчмын бохирдол, талбайн налуужилт, автозамын нөлөө бусад стандарт шаардлагыг хангаж байгаа эсэхийг судалж, зураг дээр тэмдэглэв.
- *Хөрс болон ургамлын судалгаа:* Судалгаанд хамрагдсан талбайн хөрс, ургамлын хэв шинжтэй нь уялдуулан, хөрс ургамлын дээж авах цэгийн тоог тогтоон, дээж авч бичиглэл хийв;

Материал боловсруулах үе шат: Бэлтгэл болон хээрийн судалгааны явцад бүрдүүлсэн мэдээллийг нэгтгэх, боловсруулалт хийж, дүн шинжилгээ хийж, зураглалын ажлыг гүйцэтгэв. Үүнд:

- Хөрсний хими, физикийн шинж чанарыг тодорхойлсон лабораторийн шинжилгээний дүгнэлтийг тайлбарлаж, тайланд хүснэгтээр оруулан, шинжилгээний дүнг хавсаргав;
- Газрын төлөв байдал, чанарын талаар дүгнэлт гаргав;
- Цаашид тус газрыг зүй зохистой ашиглан, хамгаалах талаар зөвлөмж боловсруулав;



- Хянан баталгааны сүлжээний зураг үйлдэж, нэгж талбар тус бүрээр паспорт бичиж, дүгнэлт гаргав;
- Антропоген, автоген, техноген нөлөөлөлд орсон газрын хил заагийг зурагт оруулах гэх мэт ажлуудыг гүйцэтгэн, тайланг хянан баталгаа хийх зааварт тусгагдсан агуулга бүтцийн дагуу бичив;
- Зургийг тоон хэлбэрт шилжүүлэхдээ ГЗМС-ийн ArcGIS 10.3 программыг ашиглаж гүйцэтгэв;

Хүснэгт 1. Загварчлал болон тооцоолох программ хангамжууд

Программ хангамж		
Нэр	Оролт	Гаралт
Программ хангамж		
ArcGIS 10.3	Цэгэн, шугаман, талбайн вектор файл болон растер зураг.	Бүх төрлийн сэдэвчилсэн болон байршлын зургууд, атрибут мэдээллийн сан
AutoCAD 2015	Цэгэн, шугаман ба сайтын мэдээлэл, газар зүйн өргөрөг болон уртраг	Газар зүйн байршлын 2D болон 3D зураг, доройтлын хэмжээ
Google earth 15	Цэгэн, шугаман ба сайтын мэдээлэл, газар зүйн өргөрөг болон уртраг	Газар ашиглалтын одоогийн байдал болон эвдрэлийн хэмжээ
Google sketchup 8.0	Цэгэн, шугаман ба сайтын мэдээлэл, газар зүйн өргөрөг болон уртраг	газар зүйн байршлын 2D болон 3D зураг, доройтлын хэмжээ
Surfer-9	Газар зүйн өргөрөгт ба уртрагийн өгсөн оноо дээр мэдээлэл	Агаарын физик бохирдлын орон зайн тархалтын түвшинг тодорхойлох
Ашиглаж буй загварууд		
Ecosystem modeling Century	Цаг агаарын мэдээ, хөрс, морфологийн бүртгэх	Бэлчээрийн менежмент, ургамлын өсөлт, усны эргэлт, хөрсний органик бодис дүр
HBV Hydrological simulation software	Агаарын температур, хур тунадас, ууршилт, хөрсний, усны параметрууд	Усны урсцыг тооцох



БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ НУТАГ ДЭВСГЭРИЙН МЭДЭЭЛЭЛ

4.1. Төслийн талбайн байршил

“Гурван хүлэгт” хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос 380 км, Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт, сумын төвөөс зүүн тийш 22 км зайд Элгэн багийн нутагт MV-022839 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд оршино.

- Талбайн хэмжээ: 727.92 га





Зураг 4. Төслийн талбайн ерөнхий байршилын зураг

Газарзүйн солбицол

Хүснэгт 2. MV-022839 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд

№	Уртгaг	Өргөрөг
1	106° 50' 41.46"	45° 25' 45"
2	106° 47' 6.53"	45° 25' 45"
3	106° 46' 21.41"	45° 25' 34.28"
4	106° 46' 21.41"	45° 25' 27.36"
5	106° 47' 12.28"	45° 25' 8.61"
6	106° 50' 41.46"	45° 24' 48.49"
Талбайн номенклатур:		L-48-94
Талбайн хэмжээ:		727.92 га



ТАНИХ ТЭМДЭГ

Лицензийн талбайн хил

Масштаб 1: 30,000




Координатын систем: WGS 1984 UTM Zone48N

Зураг 5. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг



ДОЙТЫН БУЛАГ ХХК

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Билгэх сайхан уул” ХХК-ийн MV-022839 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан



Зураг 6. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг



4.2. Физик газарзүйн нөхцөл

4.2.1. Төслийн талбайн физик газарзүйн нөхцөл

Газрын гадаргуу: Физик газарзүйн мужлалаар говийн их мужийн хойд хэсэгт шилжилтийн заагаар орших ба газарзүйн хэлбэр гадаргуугийн хэв шинжээрээ ухаа гүвээт талархаг, дов толгодлог гэсэн 2 төрлийн рельеф зонхилно.

Ухаа гүвээт талархаг рельеф нь цэрдийн хурдас тархсан Төгрөгийн хонхор, Баянцагаан, Хасагтын говь, Гурвансайханы хөндий зэрэг 1057.2-1137.5 м өргөгдсөн арав гаруй м өргөнтэй, хэдэн арван км үргэлжлэх урт хөндийнүүд тохиолдоно. Гуу жалгаар харьцангуй муу хэрчигдсэн, маш налуу хажуутай мөлгөр оройтой байдаг. Дов толгодлог рельефт талбайн хойд хэсэгт Хөтөл цагааны хяр, Баруунсайхан уул /1163.2м/, Их тэвш /1167.8м/, Хөх тээг /1212.7м/ үнэмлэхүй өндөртэй бэсрэг уулс болон бөмбөгөр оройтой налуу хажуутай толгодууд зонхилно.



Зураг 7. Билгэх сайхан уул ХХК-ийн лицензийн талбайд DJI Air 3 дрoноор авсан зураг №1



Зураг 8. Билгэх сайхан уул ХХК-ийн лицензийн талбайд DJI Air 3 дрoноор авсан зураг №2




Зураг 9. Билгэх сайхан уул ХХК-ийн лицензийн талбайд DJI Air 3 дрoноор авсан зураг №3



ДОЙТЫН БУЛАГ ХХК

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Билгэх сайхан уул” ХХК-ийн MV-022839 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан



Зураг 11. Төслийн талбайн районы газрын гадаргын налуу (градус)



4.3. Уур амьсгал


Төслийн талбайн цаг агаар нь хоногийн болон улирлын дулааны хэлбэлзэл маш ихтэй эх газрын эрс тэс уур амьсгалтай. Зун нь хур бороо багатай, өвөл хур тунадас орох нь маш бага, тогтмол цасан бүрхэвч байдаггүй. Жилийн ихэнх өдрүүд нь цэлмэг нартай байдаг. 7-р сарын дундаж температур нь $+130\text{C}$ - $+240\text{C}$, хамгийн ихдээ $+350\text{C}$ - $+410\text{C}$ хүрнэ. Өвлийн хамгийн хүйтэн сар 1-р сар, дундаж температур нь -150C - -200C бөгөөд хамгийн хүйтэн нь -320C хүрнэ. Дундаж хур тунадасны хэмжээ 80.5мм ба уулархаг газраа 200-300мм хүрдэг. Салхины дундаж хурд 3.1-5.6м/сек, хамгийн ихдээ 20м/сек хүрэх ба жилийн хавар намрын улиралд их шороон шуурга болдог.

Нарны нийлбэр цацраг ба гийгүүлэх хугацаа

Нарны цацрагийн үйл явц бол газрын гадарга орчмын агаарын температурын горимыг тодорхойлдог учраас уур амьсгал бүрдүүлэх гол зүйл юм. Газрын гадаргад ирэх нарны цацрагийн хэмжээ тэнгэрийн хаяанаас дээшхи нарны өндөр, түүний гийгүүлэх хугацаа болон үүлшилтээс шалтгаална. Тус орны хэмжээнд нар гийгүүлэх хугацаа өргөрөгөөс болж төдий л их өөрчлөгдөхгүй, харин үүлшилт хойноос урагшлах тутам мэдэгдэхүйц багасдаг учраас нар гийгүүлэх хугацаа урд зүг рүү нэмэгддэг байна. Үүнтэй уялдаж нарны нийлмэл цацраг өмнө зүгийн нутгаар харьцангуй их байхаас гадна зуны улиралд мөн их байна. Монгол орны нөхцөлд газрын гадаргад ирж байгаа нарны шулуун цацрагийн хэмжээ, сарнимал цацрагийнхаас хавьгүй илүү бөгөөд энэхүү нарны шулуун цацраг их тусч, цэлмэг өдөр олон байдаг нь нарны эрчим хүчийг улс ардын аж ахуйд ашиглах бололцоог бий болгодог. Сумын хувьд нарны нийлбэр цацраг жилд дунджаар нутгийн хойд хэсгээр 1400 квт.цаг/м², төв хэсгээр 1400-1500 квт.цаг/м², өмнөд хэсгээр 1500 квт.цаг/м² ба түүнээс дээш байна. Мөн нарны гийгүүллийн үргэлжлэх хугацааг тодорхойлж болно. Энэ нь тухайн орон нутгийн өргөрөг, тэнгэрийн хаяаны хаагдал, үүлшил зэргээс ихээхэн шалтгаална. Тус сумын хувьд нэг жилд нар гийгүүллийн дундаж хугацаа нутгийн хойд хэсгээр 3000-3100 цаг, төвийн хэсгээр 3100-3200 цаг, өмнөд хэсгээр 3200 ба түүнээс дээш цаг байдаг байна.

Агаарын даралт, салхи

Агаарын даралт газрын гадарга дээр жигд бус хуваарилагдсанаас болж салхи буюу агаарын урсгал үүсч тэр нь дулаан хүйтэн, чийг, цас, бороо гэх мэт олон үзэгдлийг нэг газраас нөгөөд зөөж байдгийн хувьд агаарын даралт уур амьсгалын чухал элемент болдог. Манай орны газарзүйн онцлог, динамик хүчин зүйлсийн нөлөөгөөр тус орны нутгаар эсрэг циклон тогтдог. Гурвансайхан сумын хувьд монголын хамгийн их салхитай байдаг нутаг юм. Энэ нь манай орны хойд ба өмнөд зүгийн агаарын урсгалын хооронд оршдог учраас их салхитай байдаг. Агаарын 1 дүгээр сарын дундаж даралт нутгийн баруун хойд хэсгээр 846-848 гПа, бусад нутгаар 844- 846гПа. Харин 7 сарын байдлаар 842 844 гПа байдаг байна. Салхины хамгийн их хурд 6-8 м/с, салхигүй өдрийн тоо 21, 15 м/с ба түүнээс хүчтэй салхитай өдрийн тоо жилд 30, цасан шуургатай өдрийн тоо жилд 10-аас дээш, явган шуургатай өдрийн тоо жилд 10, шороон шуургатай өдрийн тоо жилд 30 байдаг байна. Салхины хамгийн их хурд 40 м/с хүрч байсан.



Зураг 12. Салхины дундаж хурд, м/сек

Агаарын температур

Агаар мандлын дулааны горим бол агаар мандал дахь температурын хуваарилалт, хувьсал өөрчлөлтийн явцаар тодорхойлогдох бөгөөд энэ нь тухайн газар нутгийн уур амьсгалын үндсэн элемент болж агаар, хүрээлэн буй орчны хоорондох дулааны солилцоогоор илэрдэг зүй тогтолтой. Монгол орон эх газрын гүнд, далайн төвшнөөс дээш ихээхэн өргөгдсөн, хотгор гүдгэрийн эрс ялгаатай байдал нь агаарын температурын горимд ихээхэн нөлөө үзүүлдэг. Гурвансайхан сумын агаарын жилийн дундаж температур нутгийн ихэнх газраар 20 -4оС, өмнө зүгийн хэсэг газар 40 -6 оС байдаг байна. Их хүйтэн өдрийн тоо нийт нутгаар 10 ба түүнээс доош байна. -30оС ба түүнээс доош температуртай өдрийн тоо 20, 1 дүгээр сарын агаарын үнэмлэхүй бага температурын дундаж -30оС байдаг. Их халуун өдрийн тоо нийт нутгаар 30, +30оС ба түүнээс дээш температуртай өдрийн тоо 30, 7дугаар сарын агаарын үнэмлэхүй их температурын дундаж +34оС байна. Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 110-130 өдөр юм. Агаарын температурын хоногийн дундаж +10оС ба түүнээс дээш байх өдрийн тоо 130-150 өдөр юм.




Зураг 13. Агаарын дундаж температур, °C



Хур тунадас

Хур тунадас бол тус орны нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөлийг илэрхийлэгч чухал хүчин зүйлийн нэг юм. Тунадасны хуваарилалт газар нутгийн өндөр, ялангуяа чийг авч яваа агаарын урсгалын замд тохиолддог уулс яаж байрласнаас ихээхэн шалтгаалдаг. Гурвансайхан сумын хувьд хур тунадасны жилийн дундаж хэмжээ нутгийн хойд хэсгээр 100-150 мм, төв, өмнөд хэсгээр 50-100 мм байна. Хүйтний улирлын хур тунадасны дундаж хэмжээ 5-10 мм, дулааны улирлын хур тунадасны дулааны хэмжээ 50-100 мм байна. Нийт унах хур тунадасны ихэнх дулааны улиралд унадаг. Цасан бүрхүүл ханзарч эхлэх дундаж хугацаа 10/II, тогтвортой цасан бүрхүүлийн үргэлжлэх хугацаа 50 өдөр байдаг.



Зураг 14. Хур тунадас, мм

4.4. Ус зүй


4.4.1. Гадаргын ус

“Билгэх Сайхан Уул” ХХК –ийн Билгэх-3 нэртэй Гурван хүлэгт хайлуур жоншны ордын төслийн талбай нь Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт байрлана. Тус төслийн талбай нь Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт харьяалагдана.


Гадаргын усан сүлжээний хувьд эрт галавын далайн эрэг болох ер бусын сонин тогтоцтой Цагаан суварга хайрхан, Дэн, Монтой, Модны усны хайлаас, Өөш манхан, Хэвтээгийн хайлаас төв, Хонгор хайрхны Алаг зандан, Хавтгай уулын Барагшуунт ам, Хэвтээ босоогийн агуй зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд элбэгтэйгээс гадна Солгой Даамай, Хайрхан, Номт, Баян булаг, Хармагтай, Билгэх, Булаг хармагтай, Хөнжлийн Далай зэрэг хүн малын ундаа болсон горхи булаг элбэгтэй юм. Гэхдээ бороо хур элбэгтэй үед авто тээврээр зорчиход хүндрэлтэй болдог байна.



ДОЙТЫН БУЛАГ ХХК



Зураг 15. Сав газрын зураг



Зураг 16. Төслийн талбай орчмын гадаргын ус



Судалгааны талбайд гадаргын усны илэрц байхгүй бөгөөд зөвхөн эрчимшил ихтэй хур борооны үед бага зэргийн гадаргын урсац хуурай сайруудаар үүсэж зарим хотгор хонхор газрыг дүүргэх нөхцөлтэй байна. Иймд төслийн нутгийн гадаргын урсац уур амьсгалын хүчин зүйлс ялангуяа хур тунадасны хэмжээ, эрчимшил, хөрсний бүтэц, түүний нэвчилтийн багтаамж, чадавхаас ихээхэн хамаарна.

4.4.2. Газрын доорх ус

Гидрогеологийн судалгаа

Тухайн район нь гидрогеологийн мужлалаар уулс хоорондын хотгор ихэвчлэн артезийн ус тархсан мужид багтана. /Н.А.Маринов 1963 он/. Судалгааны талбайд тархсан гүний, бялхмал, хувирмал чулуулагт ан цавын, цэрд-дөрөвдөгчийн сэвсгэр хурдсанд нүх сүвийн ус тархжээ. Мөн гидравлик шинж чанараараа чөлөөт гадаргуутай, түрэлттэй ус тархсан байна. Газрын доорхи усны агуулагдсан чулуулгийн стратиграфийн ангилал, найрлага, газрын доорхи усны хөдөлгөөн, тархалт байрлалын нөхцөлүүдээс нь хамааруулан дараах уст үе, давхаргуудыг ялгасан байна. Үүнд:

1. Дөрөвдөгчийн хурдасны уст үе
2. Дээд юра-доод цэрдийн Могойт формацийн уст давхарга
3. Неопротерозойн карбонат ба хувирмал чулуулгийн уст давхарга
4. Палеозой-мезокайнозойн гүний чулуулгийн ан цавын ус

Дөрөвдөгчийн хурдасны уст үе: Дөрөвдөгчийн хурдасны уст үе хуурай сайруудын дагуу түүнчлэн жижиг нуурын хотгоруудад үүссэн пролюв, аллюв-пролюв, нуурын хурдсанд тархсан байна. Ус агуулагч чулуулаг нь хайрга, дайрга, шавранцар, элсэнцэр болно. Хуурай сайрын дагуу тархсан пролювийн хурдасны зузаан нь 1-3 м, уст үеийн зузаан нь 2 м хүрдэг. Энд муу мөлгөржсөн хэмхдэст хурдас зонхилно.

Аллюв-пролюв, нуурын хурдсанд шаврын материалын хэмжээ өсөж, хэмхдэсийн хэмжээ жижгэрч салаавчилсан үеүдийг үүсгэнэ. Зузаан нь 10-30 м. Уг уст үеийн усжилт харилцан адилгүй шаварлаг материалын агуулгаас ихээхэн хамаардаг. Ерөнхийдөө сул усжилттай. Хурдсуудын ундарга нь 0.5 л/с хүрдэг. Аллюв-пролюв, нуурын хурдсанд тархсан ус нь газрын доорхи усны хөдөлгөөний тогтонги нөхцөлд оршдогоос сул давстай байдаг байна. Пролувийн хурдасны ус нь химийн найрлагын хувьд сайн, эрдэсжилт бага байна. Энэ нь тэжээгдлийн сайн нөхцөлд оршдогоор тайлбарлагдана. Уг хурдсанд олон тооны гар худаг байрладаг. Агаарын хур тунадас ихтэй жилд эдгээр худгуудыг ашигладаг. Бага байх тохиолдолд гар худгууд хуурайшдаг байна. Үүнээс үзэхэд уг уст давхаргын гол тэжээгч нь агаарын хур тунадас юм.

Дөрөвдөгчийн уст үе газрын гадаргууд ойр оршдог тул /0.5-3 м/ усаа ууршилтаар ихээр алдаж, бага хэмжээгээр гипсометрийн хувьд дор байрлах бусад уст үе, давхаргуудад алддаг байна. Ууршилтад ихээр өртөх нь усны химийн найрлагад эрдэсжилт ихсэхэд нөлөөлдөг. Уг уст үе давхаргын усны химийн найрлага нь сульфатлаг, сульфат-хлорлог, хлорлог кальци-натрийн, натрийн найрлагатай. Эрдэсжилт нь 0.8-1.5 г/л, хааяа 2 г/л түүнээс дээш байдаг. Нутгийн ардууд уг уст давхаргын усыг унд болон ахуйн хэрэгцээнд хэрэглэдэг.

Дээд юра-доод цэрдийн уст давхарга: Дээд юра доод цэрдийн могойт формацийн уст давхарга нь судалгааны талбайд хамгийн их тархалттай. Уг агуулагч чулуулаг нь конгломерат, элсэн чулуу, ус үл нэвтрүүлэгч чулуулаг нь аргиллит, алевролитоос тогтоно.



Усжилт янз бүр, хэд хэдэн уст үетэй. Дээд уст үе нь 1.2-5.6 м гүнээс илрэх ба чөлөөт гадаргуутай. 0.2-0.4 л/с ундаргатай, эрдэсжилт нь 1-1.5 л/с.


Гидрокарбонат-сульфат-хлор-натрийн төрлийн холимог найрлагатай ерөнхий хатуулаг 1.73-5.07 мг.экв/л. Дээд уст үе нь агаарын тунадасны нэвчилтээр тэжээгдэнэ. Могойт формацийн хурдас нь фазын өөрчлөлт ихтэй тул дээд үеэс доод талбайн тархалт ихтэй бие даасан том уст үе тохиолдохгүй. Харин гидравлик холбоотой жижиг үеүдтэй. 1:500 000 масштабтай гидрогеологийн зураглалын ажлын үр дүнгээс үзвэл 2.0-7.8 м түвшний бууралтад харгалзан 4.7-4.8 л/с ундаргатай. Эрдэсжилт нь 1.1-1.3 г/л. Химийн найрлагаар нь сульфат-хлоридын ба холимог найрлагатай төрөлд хамаарна. Доод уст үеүд нь тектоник хагарлаар хүрээлж байгаа ан цавын уст үеүдээс, мөн агаарын тунадасны нэвчилтээр тэжээгдэнэ. Уг уст давхаргын усыг нутгийн ардууд ахуй ундандаа хэрэглэдэг. Неопротерозойн карбонат ба хувирмал чулуулгийн уст давхарга: Энэ уст үе нь судалгааны талбайн төв хэсгээр өргөн тархжээ. Ус агуулагч чулуулаг нь ан цавархаг шохойн чулуу, шохойлог элсэн чулуу, занараас тогтоно. Усны гүний түвшин 0.5-8 м, ундарга 0.05-3.4 л/с гэж тогтоогджээ /Л. В. Заботкин/. Эрдэсжилт 1.2-1.6 г/л сулавтар давсархаг, хлорлог, сульфатлаг, натрийн төрлийн найрлагатай. Усны ерөнхий хатуулаг 5.0-8.1 мг.экв/л. Карбонат чулуулгийн захын хэсгээр буюу тасрал эвдрэлд өртсөн хэсгээр ан цав-карстын усны үлэмжхэн нөөц байж болох талтай.

Хувирмал чулуулаг нь карбонат чулуулагтай хиллэн багахан талбайд тархжээ. Ус агуулагч чулуулаг нь ан цавтай янз бүрийн найрлагатай байна. Усжилт бага. Энэ уст үеийн ус нь цэнгэг, 1 г/л хүртэл эрдэсжилттэй. Гидрокарбонат, сульфат-гидрокарбонат-натрийн найрлагатай. Усны ерөнхий хатуулаг нь 3 мг экв/л-ээс хэтрэхгүй. Устөрөгчийн орчин рН=6.8 Палеозой-мезокайнозойн гүний чулуулгийн ан цавын ус: Гүний чулуулаг нь судалгааны талбайд өргөн тохиолдоно. Ус агуулагч чулуулаг нь ан цавшсан гранит, гранодиорит, диорит, диорит-порфир зэрэг болно. Усжилт бага. Худгуудын ундарга 0.1-0.2 л/с хагарал эвдрэлийн бүсэд 1.5 л/с хүртэл /Өөхт худаг/ ундаргатай. Гүний чулуулаг дахь ус нь 0.9-3 мг/л эрдэсжилттэй, гидрокарбонат-сульфат-хлорид-натрийн найрлагатай 3.6-12.1 мг экв/л хатуулагтай байна.

Судалгааны талбай нь газрын доорх усны хангалтын нөхцөлөөр муу мужид багтдаг бөгөөд газрын доорх ус хомс тэжээгддэг, гадаргын усны урсац бүрэн алдагддаг байна. Уг талбайд газар доорх усны гол тэжээл нь агаарын хур тунадас юм.

Уст цэгт хийсэн химийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд химийн найрлага нь ихэвчлэн холимог, эрдэсжилт нь 1-1.5 г/л байна. Энэ нь тухайн ус хангалтын нөхцөлөөр муу районд унд болон ахуйн хэрэгцээнд хэрэглэж болох бөгөөд цаашид химийн бактериологийн шинжилгээнд дээж авч байнга шинжлүүлж байх шаардлагатай. Дээр ялгарсан уст үе давхаргуудаас төвлөрсөн усан хангамжийн хэрэгцээг хангаж болох нь дээд юра-доод цэрдийн Могойт формацын уст давхарга юм.

Энд цооногуудын ундарга 4.7-7.8 л/с, бууралт нь 2.0-7.8 м байна. Эрдэсжилт нь 1.1-1.2 г/л. Бусад уст үе давхаргуудын усжилт бага хэмжээний хэрэгцээг хангах боломжтой.



Зураг 17. Уст цэгийн байршил

Талбайн газрын доорх усны бүрэлдэн тогтох болон тархалтын зүй тогтол нь ус агуулагч чулуулгийн тогтцоос шалтгаалан газрын доорх усны шүүрэлт болон ус агуулагч чулуулгийн усжилт жигд бус горимыг үүсгэнэ.

Газрын доорх усны тэжээлийн голлох эх үүсвэр нь агаарын хур тунадас байх ба сэвсгэр хурдас дахь уст үе давхаргын хувьд зэргэлдээ орших гүний чулуулгийн газрын доорх усны урсцаар тэжээгдэнэ. Хүдрийн биетийг агуулагч чулуулгийн хэмжээнд өрөмдсөн хайгуулын цооногууд нь 1175.5 м-1157.7 м-ийн түвшинд толгодын орой хэсгээр байрлана.

Хайгуулын өрөмдлөгийн тухайлбал В3ДН2303, В3ДН2308, В3ДН2310 зэрэг цооногуудад 40-80 м-ийн интервалд ус алдаж байснаас өөр усжилтын талаар мэдээлэл илрээгүй болно. Өрөмдлөгийн ажлын явцад ордын талбай түүний ойр орчимд бага болон гүнд газрын доорх ус илрээгүй бөгөөд ашиглалтын үед дөрөвдөгчийн бага гүний ус талбайд нэвчих боломжгүй.

4.5. Хөрсөн бүрхэвч, ан амьтан

Судалгааны талбайн хөрсөн бүрхэвч нь хөрс-газарзүйн мужлалаар Умард говийн заримдаг цөлийн цөлөрхөг хээрийн бор хөрсний бүсэд багтана. Тус талбайн ихэнх хэсэгт толгодын нимгэн, сайр чулуурхаг цайвар хүрэн элсэнцэр хөрс тархсан.

Судалгааны талбай нь хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их мужид хамаарна. Энд хур чийг бага, хөрсний органик үлдэгдлийн хэмжээ мөн бага ургамал тачир сийрэг. Хөрсний үе давхарга дунджаар 4-5 жилд нэг удаа нэвт норж, угаагдал бүхий чийгийн горим ноёрхох тул хээрийн хөрсний дээд хэсэг нь карбонатгүй байхаас гадна бүр нилдээ карбонатгүй буюу бага карбонаттай хар шороон, хар хүрэн хөрс тохиолдоно.



Карбонатын давсны хуримтлал хөрсөнд нэвчиж цайвартсан гурил шиг нунтаг хэлбэртэй байхаас биш хатуурсан бөөгнөрлүүд үүсэхгүй. Зөвхөн сайр чулуунуудын доод талд карбонатын хатуу өнгөр дарайж тогтдог. Салхины нөлөө хүчтэй харгайгаар хөрсний гадарга дээр сайр чулуурхаг ба элсэн хучаас үүсгэдэг.

4.6. Ургамлан нөмрөг

“Билгэх сайхан уул” ХХК -ийн Гурван хүлэгт хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн болон түүний бүс нутагт хийсэн ургамлын аймаг хийгээд ургамалжилтын ажиглалт судалгаанаас үзэхэд цөлөрхөг хээрийн бүсэд хамаарагддаг байна.

Төслийн талбай нь ургамал-газар зүйн мужлалын хувьд А.А.Юнатовын (1952) ангиллаар Евро Азийн хээрийн мужийн Дагуур-Монголын хээрийн провинцийн Дорнод Монголын хээрийн тойрогт Академич Н.Өлзийхутагийн ангиллаар Дорнод говийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна.



Зураг 18. Монгол орны ургамал-газарзүйн мужлал

Хээрийн бүс: монголын хээр, Төв Азийн цөлийн зааг нэлээд эрт үүсэж бий болсон, биеэ даасан үүсэлтэй, бүсэд ургадаг зонхилогч ургамлуудтай байдгаараа онцлог бөгөөд тэр нь Их нууруудын хотгор Олон нуурын хөндий, Дорноговийн нам өндөрлөг, Говь Алтайн нурууг хамаарна. Цөлөрхөг хээрийн бүсэд жилдээ 100-125мм тунадас унадаг, ургах хугацаа 170-190 хоног үргэлжилдэг. Цөлөрхөг хээрт жижиг үетнүүдээс гадна гуравласан боролзой, төлөгчдүү боролзой, таана орог тэсэг, бор бударгана, навчгүй баглуур, нохой шээрэнгэ, улаан харанга, хамхуул, монгол догор, данхар хависхана, шарилж, шаваг элбэг ургана.



БҮЛЭГ 5. ХӨРСНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАР ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Танилцуулга

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Билгэх сайхан уул” ХХК-ийн төслийн талбайд хөрсөн бүрхэвчийн өнөөгийн төлөв байдал болон хөрсний шимт үе давхаргуудын хими-физик шинж чанар, хөрсний шимт үе давхаргын дундаж зузаан болон нөөц, бохирдлын түвшин, хөрсөн бүрхэвчид нөлөөлж буй гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодруулах зорилгоор хийж гүйцэтгэсэн.

5.1. Судалгааны аргазүй

Багаж хэрэгсэл: Хөрсний талбайн судалгаанд хүрз, метр, дээжийн уут, дээжийн хутгуур, фото аппарат, GPS, 10%-ийн давсны хүчлийн уусмал зэрэг багаж хэрэгсэл ашигласан.



GPS



Хүрз



Хөрсний дээж зөөвөрлөх уут



Бичиглэлийн самбар

Талбайн судалгаа ба хөрсний дээж авалт: Судалгааны талбайд хөрсний хээрийн судалгаа буюу дээж авалт болон ажиглалт хэмжилтийг 2025.10.01-нд хийж гүйцэтгэсэн. Энэ удаагийн судалгааны хүрээнд хөрсний дээжлэлтийг нийт 15 цэгт хийж, агрохими, хүнд металл, хөрсний эрүүл ахуйн дээжийг тус бүр авсан. Хөрсний хүнд металлын дээжийг холимог байдлаар авсан. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990” стандартыг баримталсан. Хөрсний дээжлэлт хийсэн цэгүүдийн талаарх мэдээллийг хүснэгтэд үзүүлэв.



Хүснэгт 3. Хөрсний дээж авсан цэгийн ерөнхий мэдээлэл

Цэгийн дугаар	Дээж авсан газар	X	Y
Цэг-1	Гадна ариун цэврийн байгууламж	106.798889	45.425000
Цэг-2	Хогийн цэг	106.799444	45.425000
Цэг -3	Хашаа	106.799167	45.425833
Цэг-4	Шинэ кэмп	106.796111	45.425000
Цэг-5	Гэр кэмп	106.797500	45.424722
Цэг-6	Овоолго	106.796111	45.418889
Цэг-7	Шимт хөрсний овоолго	106.791389	45.422222
Цэг-8	Засварын талбай	106.789722	45.421944
Цэг-9	ШТС	106.789350	45.421209
Цэг-10	Жонш ялгах талбай	106.795278	45.422778
Цэг-11	Уурхайн ухаш тээврийн зам	106.793611	45.420278
Цэг-12	Уурхайн хашааны зүүн зах, уулын бэл	106.805000	45.425000
Цэг-13	Уурхайн хашааны гадна урд, уулын орой	106.802222	45.422500
Цэг-14	Уурхайн хашааны гадна урд, уулын өвөр	106.801944	45.421389
Цэг-15	Уурхайн хашааны баруун зах	106.793566	45.418442



Зураг 19. Хээрийн судалгаанд ашигласан багаж хэрэгсэл



Лабораторийн задлан шинжилгээ: Талбайгаас авсан дээжүүдэд хими-физик шинж чанарын ерөнхий үзүүлэлтүүдийг “Нарт шуун консалтинг” Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид доорх аргаар тодорхойлов. Үүнд:

№	Хөрсний үзүүлэлтүүд	Задлан шинжилгээний арга
1	Ялзмагийн бодис	Тюрин
2	Органик нүүрстөрөгч	Шатаалтын алдагдал
3	Урвалын орчин (pH)	Потенциометрийн (H ₂ O, 1:2.5)
4	Карбонат	Эзлэхүүний
5	Цахилгаан дамжуулах чанар (EC)	Ионометр
6	Хөдөлгөөнт фосфор	Спектро фотометр
7	Хөдөлгөөнт кали	Дөлт фотометр


Хөрсөн дэх онцгой хортой (Cd, Cr, Pb) ба хортой био-идэвхт (Cu, Ni, Zn) элементүүдийг мөн дээрх лабораторид (AAS)-ийн багажаар тодорхойлсон.

Хөрсний зураглал: Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил болон хөрсөн бүрхэвчийн тархалт, эвдрэл талхагдлын зураглалыг хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS Pro 3.3 программ дээр хийж гүйцэтгэсэн. Хэвлэлийн эхийг АЗ хуудсан дээр 1:20500 масштабтай бэлдсэн.

5.2. Судалгааны үр дүн

Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн тархалт, онцлог

Төсөл хэрэгжих талбай орчмын бүс нутаг нь өндөр уулын хээр бүхий экосистемтэй, д.т.д 1734-1890 м үнэмлэхүй өндөртэй уул бүхий газарт байрлах бөгөөд хөрсөн бүрхэвч нь хад чулуу болон Уулын хээрийн хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг нимгэн ба сайргархаг Хүрэн хөрс тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин бага буюу ялзмагийн агууламж нь 1-2%, нимгэн үе давхаргатай, хөрс үүсгэгч хурдас нь том жижиг чулуу болон нарийн элсэрхэг ба шаварлаг хагшаастай, хэврэгдүү бүтэцтэй учраас шороон зам зэрэг техникийн нөлөөтэй эвдрэл талхагдалд тэсвэр дунд зэрэг, эргэж нөхөн сэргэхдээ мөн удаавтар байна. Талбайн ерөнхий онцлог нь хонхор хотос болон гуу жалга бүхий газруудад салхины ба усны нөлөөгөөр зөөгдөж ирсэн элсэрхэг болон тоосорхог хурдас хуримтлалтай, гүвээрхэг хэсгээрээ чулуурхаг ба сайргархаг, нугачаа хэрчигдэл ихтэй байна. Хүний үйл ажиллагааны нөлөөтэй эвдрэл талхагдал одоогоор дунд зэрэг байна. Газрын гадаргын геоморфологийн хэлбэр нь уул үүслийн атираашил гаралтай, хэмжээний хувьд макро рельефийн төрөлд хамаарах бөгөөд талбайн ойр орчмын уулс ус салхины нөлөөгөөр элэгдэж хуримтлагдах замаар үүссэн байна.



Зураг 20. Талбайн хөрсөн бүрхэвч

5.1.1. Зонхилон тархсан хөрсний гадаргын ба үе давхаргын морфологи шинж чанар Хөрсний морфологийн шинж чанар

- Газрын гадарга : Тал хөндий
- Бичил гадарга : Хажуугийн налуу
- Налуу : 0-20° (градус)
- Чулууны бүрхэц, % : чулуутай
- Зонхилох ургамал : Үетэн
- Ургамал бүрхэц % : 35-40%
- Хөрсний нэр : Цөлөрхөг хээрийн бор хөрс

Үе давхарга (гүн, см)

А (0-12) Хүрэн бор өнгөтэй, бөөмөрхөг хуурай, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Жижиг хайрга чулуутай, ургамлын үндэстэй, чулуулгийн гадна талд карбонатын өнгөртэй.

В (12-25) Цайвар элсэн өнгөтэй, бөөмөрхөг хуурай, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Жижиг хайрга чулуутай, ургамлын үндэстэй, чулуулгийн гадна талд карбонатын өнгөртэй.



Зураг 21. Сайр чулуурхаг цайвар хүрэн хөрсний гадаргын ба үе давхаргын төлөв

Хөрсний үржил шимийн түвшин ба хими-физик шинж чанар

Хүснэгт 4. Хөрсний хими шинж чанар

Дээжний дугаар	Гүн, см	pH H ₂ O	Давс %	ЦДЦ, dS/m	Ялзмаг, %	CaCO ₂ , %	NO ₃ мг/100г	(Ca+Mg) мг/100 гр	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca	Mg	P ₂ O ₅ , мг-экв	K ₂ O мг-экв
Дээж-6	0-15	8.77	0.103	0.252	2.56	0.96	0.99	27	11	16	4.7	18
Дээж-7	0-15	8.40	0.037	0.089	1.26	0.48	0.30	18	13	5	4.2	20.2
Дээж-8	0-15	8.52	0.063	0.149	1.34	1.12	0.56	18	9	9	5.22	18.8
Дээж-9	0-15	8.34	0.045	0.106	1.46	0.80	0.38	19	10	9	3.5	30
Дээж-10	0-15	8.32	0.054	0.129	1.53	1.44	0.47	31	20	11	2.1	26
Дээж-11	0-13	8.32	0.045	0.106	2.11	0.8	0.37	24	12	12	4.5	35
	13-30	8.36	0.042	0.101	1.72	0.8	0.35	25	11	14	4.52	23
Дээж-12	0-15	8.33	0.037	0.089	1.56	1.28	0.3	19	11	8	3.96	32
	15-30	8.31	0.039	0.092	1.39	1.44	0.31	19	10	9	4.46	31
Дээж-13	0-15	8.28	0.039	0.094	1.67	1.44	0.32	21	12	9	4.1	44
	15-30	8.29	0.042	0.099	1.26	1.12	0.35	21	13	8	4.3	26
Дээж-14	0-10	8.27	0.037	0.089	1.59	0	0.31	17	12	5	4.82	16
	10-30	8.22	0.047	0.111	1.43	1.76	0.39	19	11	8	4.76	11
Дээж-15	0-15	8.22	0.043	0.103	1.37	1.28	0.36	16	9	7	4.68	6
	15-30	8.34	0.050	0.12	1.49	1.92	0.43	18	7	11	5.06	10



Хөрсний үржил шимийн түвшнийг тодорхойлдог голлох үзүүлэлт болох хөрсний ялзмаг, хөдөлгөөнт фосфор, кали болон хөрсний хими шинж чанарын үзүүлэлт болох хөрсний урвалын орчин (рН), карбонатын агууламж, хөрсний хялбар уусах давсжилт (ЕС) гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон бөгөөд үзүүлэлт тус бүрийн үр дүнгийн талаар доор дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Хөрсний урвалын орчин (рН): Энэ үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний рН-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэж үздэг. Ерөнхийдөө хөрсний урвалын орчин дунд зэрэг хүчиллэгээс дунд зэрэг шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад тохиромжтой гэж үздэг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний урвалын орчин 8.2-8.5 хооронд буюу дунд зэрэг шүлтлэг орчинтой байгаа нь ургамал ургахад тохиромжтой байна.

Хөрсний карбонатжилт: Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй (CO₃)-тэй нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Хөрсөнд янз бүрийн анхдагч болон хоёрдогч карбонатууд байдаг. Эдгээрээс Хамгийн түгээмэл хэлбэр нь кальцид (CaCO₃) болон доломит [CaMg(CO₃)₂] юм. Карбонат нь хөрсний рН-ийн орчин суурилаг буюу шүлтлэг шинж чанартай байгааг илэрхийлдэг. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгдэлд тэсвэртэй байдал, боломжит чийгийн багтаамжид нөлөөлдөг. Хөрсийг карбонатын агууламжаар нь 0% карбонатжаагүй, 0-2% сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% маш хүчтэй карбонатжсан гэж үнэлдэг. Хөрсний карбонатын агууламж дунд зэрэг буюу <10% байхад тохиромжтой гэж үзнэ. Судалгааны үр дүнгээс харахад ерөнхийдөө маш бага карбонаттай байна.

Хөрсний ялзмагийн агууламж: Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодис нь ойролцоогоор 60% нүүрстөрөгч, 6% азот болон фосфор, хүхэр зэрэг макро микро элементүүдийг өөртөө агуулж байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд зэрэг, >5% их ялзмагтай гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний ялзмагийн агууламж дээд үе давхаргад 1.3-2.5% буюу бага байгаа нь үржил шимээр ядмагдуу байгааг илтгэж байна.

Хөрсний хялбар уусах давсжилт (ЕС) : ЕС буюу хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Энэ нь хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд ЕС нь ургамлын ургац, ургамалд тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Хөрсөн дэх илүүдэл давс нь хөрс-усны тэнцвэрт байдалд нөлөөлж ургамлын өсөлтийг сааруулдаг. Мөн хөрсний ЕС-ийн үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Хөрсийг ЕС1:2.5-ээр нь 0.0-0.26 dS/m сул давсархаг, 0.26-0.77 dS/m дунд зэрэг давсархаг, 0.77-1.78 dS/m их давсархаг, 1.78-3.55 dS/m маш их давсархаг, >3.55 dS/m хэт их давсархаг гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний үе давхаргад хялбар уусах давсжилт <0.089 dS/m-0.2 буюу маш сул давсжилттай байна. Хөрсний хялбар уусах давсжилт ерөнхийдөө бага байгаа нь үржил шимийн макро болон микро элементүүдийн хангамж бага байгааг илтгэж байна.



Хөрсний хөдөлгөөнт кали, фосфор Хөрсний азот, фосфор, кали (N,P,K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Фосфор (P) нь ургамлын эрүүл өсөлтөд шаардлагатай олон тооны чиг үүрэг гүйцэтгэж, бүтцийн чадавх, ургацын чанар, үрийн гарц зэрэгт илүү хувь нэмэр оруулдаг. Хөрсөн дэх фосфорын пентоксид (P₂O₅) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксидаг агууламжаар нь <1мг/100г бол бага хангамжтай, 2-3 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Кали (K) нь ихэвчлэн "чанарын элемент" гэж нэрлэгддэг бөгөөд ургамлын чанар, хэмжээ, хэлбэр, өнгө, амт гэх мэт олон шинж чанаруудад нөлөөлдөг. Хөрсөн дэх калийн исэл (K₂O) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл (K₂O)-ийг агууламжаар нь <10 мг/100г бол бага хангамжтай, 10-20 мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад хөрсний хөдөлгөөнт фосфорын хангамж 2.1-5 мг/кг сайн хангамжтай байна. Хөдөлгөөнт калийн хангамж 6-44 мг/кг буюу бүх зүсэлтийн дундаж утга 19.3 байгаа нь сайн хангамжтай байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн: Хөрсний ус-физик шинж чанарууд ерөнхийдөө хөрсний механик бүрэлдэхүүнээс ихээхэн хамааралтай байдаг бөгөөд механик бүрэлдэхүүн нь 2мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракци нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь ус чийг тогтоон барих чадвар муутай, ургамалд хялбар ашиглагдах үржил шимээр ядмаг байдаг байдаг ч ургамалын үндэс чөлөөтэй ургаж хөгжих боломжоор илүү байдаг. Судалгааны үр дүнгээс харахад элсэнцэр болон шавранцар бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 5. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Гүн, см	Механик бүрэлдэхүүн, % ширхгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж- 6	0-15	2.6	44.3	28.6	10.2	5.9	8.4	24.5
Дээж- 7	0-20	3.6	70.1	13.2	7.2	1.6	4.3	13.1
Дээж- 8	0-20	2.3	62.8	16.5	9.8	2.9	5.7	18.4
Дээж- 9	0-20	3.1	64.7	14.6	7.2	4.6	5.8	17.6
Дээж- 10	0-20	2.9	66.5	13.8	9.1	2.4	5.3	16.8
Дээж- 11	0-13	1.7	61.1	15.3	9.7	5.8	6.4	21.9
	13-30	1.9	64.9	14.5	11.3	2.6	4.8	18.7
Дээж- 12	0-15	2.1	63	14.4	10.4	4.9	5.2	20.5
	15-30	3.2	65.8	12.9	8.7	5.3	4.1	18.1
Дээж- 13	0-15	4.3	67.0	11.4	7.5	4.6	5.2	17.3
	15-30	3.9	64.2	10.8	10.6	3.8	6.7	21.1
Дээж- 14	0-10	5.6	70.3	9.7	7.2	2.3	4.9	14.4
	10-30	3.7	71.1	9.8	6.7	3.6	5.1	15.4
Дээж- 15	0-15	0.9	69.6	12.6	10.3	2.9	3.7	16.9
	15-30	0.8	59.1	16.5	12.5	4.2	6.9	23.6

Хөрсний хүнд металлын өнөөгийн түвшин

Хортой хүнд металл гэдэгт дараах 6 хүнд металл багтана. Үүнд: Хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), зэс (Cu) орно. Эдгээрээс Cd, Cr, Pb нь онцгой хортой, Co, Cu, Ni, Zn нь хортой био-идэвхт хүнд металлууд гэж үздэг. Онцгой хортой хүнд металлууд нь амьд организмд учруулах хор нөлөөлөл ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхүүлэх хүртэл аюултай байдаг. Харин хортой био-идэвхт хүнд металлууд нь хоруу чанарын хувьд онцгой хортой хүнд металлуудаас арай



бага, тодорхой хэмжээгээр амьд организмд байх ёстой боловч амьд организмд их хэмжээгээр хуримтлагдвал эндемик буюу орогномол өвчин үүсгэдэг аюултай.

Хүснэгт 6. Хөрсний хүнд металлуудын агууламж


Дээжний нэр	Дээжний гүн, см	Онцгой хортой хүнд металлууд			Био-идэвхт хүнд металлууд		
		Cd	Cr	Pb	Cu	Ni	Zn
Дээж-6	0-20	0	34.35	41.65	45.7	48.55	66.15
Дээж-7	0-20	0	3.15	16.65	12.95	7.5	33.9
Дээж-8	0-20	0	21.9	47.2	42.55	92.85	106.25
Дээж-9	0-20	0	40.65	33.35	18.4	18.2	54.8
Дээж-10	0-20	0	34.35	36.1	26.15	29.63	59.6
Дээж-11	0-13	0	9.4	33.35	19.85	18.55	56.2
	13-30	0	25	22.2	21.85	21.8	59.6
Дээж-12	0-15	0	12.5	25	15.25	17.15	57.3
	15-30	0	12.5	25	15.5	15.7	41.25
Дээж-13	0-15	0	37.5	22.2	10.9	12.85	32.8
	15-30	0	25	25	10.05	16.8	34.95
Дээж-14	0-10	0	12.5	8.35	7.75	9.65	27.5
	10-30	0	25	25	12.05	11.45	31.4
Дээж-15	0-15	0	12.5	27.8	15.5	15.7	42.5
	15-30	0	28.1	30.55	20.4	19.3	52.7
<i>Элсэрхэг хөрс</i>		<i>1</i>	<i>60</i>	<i>50</i>	<i>60</i>	<i>60</i>	<i>100</i>
<i>Шавранцар хөрс</i>		<i>1.5</i>	<i>100</i>	<i>70</i>	<i>80</i>	<i>100</i>	<i>150</i>
<i>Хүлцэх агууламж (MNS 5850:2019)</i>		<i>3</i>	<i>150</i>	<i>100</i>	<i>100</i>	<i>150</i>	<i>300</i>

Хөрсний дээжид хүнд металлын шинжилгээг атомын шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан үр дүнг (MNS 5850:2019) Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад (Дээж 8)-аас бусад дээжинд элсэрхэг болон шавранцар хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй буюу хэвийн түвшинд байна. Харин (Дээж 8) буюу засварын талбайгаас авсан дээжинд Цайр(Zn) болон Никель (Ni)-ийн агууламж элсэрхэг хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлттэй байна.

Хөрсөн бүрхэвчийн эвдрэл, талхагдал.

Төслийн нийт талбайн хэмжээнд уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд өртсөн нийт 10.26 га газар байна. Билгэх сайхан уул ХХК нь 2025 оноос төслийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн байна.


№	Хөрсний төрөл	Талбай, м ²
1	Уурхайн карьер	17839.4
2	Овоолго	21348.4
3	Шимт хөрсний овоолго	2653.7
4	Түр овоолго	2354.78
5	Засварын талбай	3979.9
6	Хаягдал чулуулгийн талбай	3577.48
7	Гэр кемп болон шинэ кемп	2590
8	ШТС	107.6
9	Зам	48187.6
	Нийт	102636.8 /10.26/



Зураг 22. Төслийн талбайн газар ашиглалт, хөрсний эвдрэлийн зураг



Зураг 23. MV-022839 тоот тусгай зөвшөөрлийн талбайн өнөөгийн төлөв байдлын фото №1



Зураг 24. Уурхайн ухааш болон овоолго DJI AIR 3 дрoноор авсан зураг



Зураг 25. Уурхайн ажилчдын кемп орчим

Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт

Хүснэгт 7. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ, 1гр хөрсөнд

Дээж авсан гүн (см)	Нянгийн тоо	Гэдэсний савханцрын титр (<i>E.coli</i>) MNS3297:2019			Перфрингенсийн таньц MNS3297:2019	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
Дээж-1	0-15	$5.9 \cdot 10^5$	≥ 0.1	1	≥ 0.1	1



Дээж авсан гүн (см)		Нянгийн тоо	Гэдэсний савханцрын титр (<i>E.coli</i>) MNS3297:2019			Перфрингенсийн таньц MNS3297:2019	
			Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
Дээж-2	0-15	4.4*10 ⁵	≥0.1	1	≥0.1	1	
Дээж-3	0-15	3.8*10 ⁵	≥0.1	1	≥0.1	1	
Дээж-4	0-15	6.1*10 ⁵	≥0.1	1	≥0.1	1	
Дээж-5	0-15	4.8*10 ⁵	≥0.1	1	≥0.1	1	

Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS3297:2019 стандартад зааснаар нийт нянгийн тоо 1гр-д 10⁶ -аас хэтрэхгүй, халдварт өвчин үүсгэгч гэдэсний бүлгийн савханцар (*E.coli*), *Cl.perfringers* зэрэг бактериуд илрэх ёсгүй байдаг. Дээрх хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг MNS3297:2019 стандарттай харьцуулахад нийт бактерийн тоо хэтрээгүй, *E.coli* болон *Cl.perfringers* >0.1 буюу цэвэр түвшинд байна.

Дүгнэлт

- Төслийн талбайд бүхэлдээ сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс тархсан байна. Талбайн ерөнхий онцлог нь хонхор хотос болон гуу жалга бүхий газруудад салхины ба усны нөлөөгөөр зөөгдөж ирсэн элсэрхэг болон тоосорхог хурдас хуримтлалтай, гүвээрхэг хэсгээрээ чулуурхаг ба сайргархаг, нугачаа хэрчигдэл ихтэй байна. Хүний үйл ажиллагааны нөлөөтэй эвдрэл талхагдал одоогоор дунд зэрэг байна.
- Хөрсөн дэх хүнд металлын агууламж Дээж 8-аас бусад цэгт стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй, харин Дээж 8 буюу засварын талбайгаас авсан дээжнээс Цайр болон никель агууламж элсэрхэг хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлттэй гарсан байна.
- Хөрсний микробиологийн шинжилгээний үр дүнг Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS3297:2019 стандарттай харьцуулахад стандартаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй хэвийн түвшинд байна.

Зөвлөмж

- ✓ Цаашид хөрсний мониторингийн судалгааг хийж, хөрсний үржил шим, бохирдол, үнэлгээний үзүүлэлтүүдийг хянаж зорилгоор жилд 2 доошгүй удаа хөрсний дээж авч хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж ажиллах;
- ✓ Ахуйн болон үйлдвэрийн гаралтай шингэн, хатуу хог хаягдлууд үүсэж түүнийг цуглуулах, устгах, халдваргүйжүүлэх арга хэмжээ аваагүйн улмаас шимт хөрс, хөрсний үржил шим, физик, химийн үзүүлэлт, гадаргын болон хөрсний ус, агаарын чанар, хүн, амьтны эрүүл мэнд зэрэг үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлж болзошгүй тул “Билгэх сайхан уул” ХХК-н уурхайн хүрээнд хог хаягдлын төвлөрсөн цэгийг бий болгож хог хаягдлын менежментийн хөтөлбөрийг боловсруулан ажиллах шаардлагатай. Хог хаягдлын цэгийг дараах байдлаар ангилан ялгана.
 - “Хог хаягдал түр хадгалах цэг”
 - “Аюултай хог хаягдлыг устгах цэг” (хүн, мал, амьтан, ургамлыг өвчлүүлэх, тэдгээрт хор хөнөөл учруулах, үр удамд нь сөргөөр нөлөөлөх, байгаль орчны тэнцлийг алдагдуулахад хүргэх шатах, тэсрэх, хордуулах, түлэх, халдварлах,



эрчимтэй урвалжих шинж чанар бүхий бодисыг агуулсан хог хаягдлыг устгах зориулалтын байгууламж)

Хог хаягдал түр хадгалах цэгийг байгуулах. Тухайн цэгийг байгуулахад дараах арга хэмжээг зайлшгүй тусгана.

- Хог хаягдал хур борооны усаар урсах ааргүй байх
 - Салхины нөлөөгөөр хог хаягдал хийсэхгүй байх
 - Гал түймэр гарах болон түүний тархахаас сэргийлэх
 - Хортон шавж болон халдвар тараагчдыг үүрлэхээс сэргийлэх гэх мэт асуудлуудыг авч үзсэн байх шаардлагатай.
- ✓ Төлөвлөгөөт хугацааны дагуу хог хаягдлыг ангилан ялгаж, бөөгнүүлэн хамах, зайлуулах, тарж бутрахаас сэргийлэх, ариутган, халдваргүйжүүлэх арга хэмжээ авч ажиллах;
 - ✓ ШТС болон засварын төвийн талбайг хатуу хучилттай, хайрган хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх;
 - ✓ Шатах тос, тосол, металл агуулсан хаягдлыг зөв ангилж хадгалах, хөрсөнд нэвчилт асгаралт үүсэхээс сэргийлэх, асгарсан тохиолдолд хөрсийг элс болон шингээгч ашиглан цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авч ажиллах,
 - ✓ Үйлдвэрлэлийн болон аж ахуйн шалтгаант бохирдол үүсэхээс сэргийлэх зорилгоор хог хаягдлын ангилан ялгалт, хадгалалт, зайлуулалтын дэглэмийг сайжруулж, металлын эх үүсвэр болох боломжтой материалын хяналт, бүртгэлийг чанд мөрдөх;
 - ✓ Уурхайн талбай дотор олон салаа зам гаргахгүй байх, хил хязгаарыг тэмдэгжүүлэх;
 - ✓ Хүний үйл ажиллагаатай холбоотой үүссэн ландшафтыг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008”-ын дагуу тухайн газар нутгийн унаган төрхөд нь ойртуулан техникийн нөхөн сэргээлтийг ажлыг хийж гүйцэтгэнэ;



БҮЛЭГ 6. УРГАМЛАН НӨМРӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАР, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Танилцуулга

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Билгэх сайхан уул” ХХК-ийн MV-022839 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн ургамлан нөмрөгийн төлөв байдлын хээрийн хэмжилт судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд хээрийн судалгаагаар төслийн талбайтай танилцах, хээрийн хэмжилт бичиглэл хийх, ургамлын суурь мэдээ материал цуглуулах, нөлөөлөлд өртсөн талбайн ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж баталгаажуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

6.1. Судалгааны аргазүй

Төслийн талбайд хамаарагдах газар, түүний ойр орчмын газруудыг хамруулсан ургамлын аймаг, ургамалжилтын судалгааг гүйцэтгэсэн. Судалгааны явцад ургамлан үндсэн бүлгэмдлийн солигдол болон гадаргын өөрчлөлтөд тулгуурлан ургамлын зүйлийн бүрдлийг уламжлал арга болох сет маршрутаар гүйцэтгэсэн ба геоботаникийн бичиглэлийг 1 x 1 метр талбайд бичиглэл үйлдсэн. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн болоод ургамал бүрийн статусыг тогтоохыг оролдов.

- Зүйлийн бүрэлдэхүүн: Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо зүйлүүдийг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн латин, монгол нэрийг (Грубов, 1982) бүтээлд зааснаар тус тус нэрлэсэн.
- Арви: Ургамлын зүйлийн арвид (Друде, 1913) нүдэн баримжааны аргаар үнэлгээ өгсөн.
- Тусгаг бүрхэц: Ургамлын зүйлийн тусгаг бүрхцийг (Раменский, 1938) 1м²-ийн хэмжээст тороор тодорхойлсон.
- Үзэгдэл зүй: Ургамлын зүйл тус бүрийн хөгжлийн үе шатыг (Бейдемман, 1954) аргаар үнэлж (Алехин, 1925) тэмдэглэгээгээр тэмдэглэсэн.
- Ургац: Бүлгэмдлийн ургацыг 3 давталттайгаар 1м² талбайгаас газрын хөрснөөс дээш 0 см-ийн өндөрт хайчилж агаарын хуурай жинг жигнэж тодорхойлсон.

6.2. Ургамлан нөмрөгийн онцлог

“Билгэх сайхан уул” ХХК -ийн Гурван хүлэгт хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн болон түүний бүс нутагт хийсэн ургамлын аймаг хийгээд ургамалжилтын ажиглалт судалгаанаас үзэхэд цөлөрхөг хээрийн бүсэд хамаарагддаг байна.

Төслийн талбай нь ургамал-газар зүйн мужлалын хувьд А.А.Юнатовын (1952) ангиллаар Евро Азийн хээрийн мужийн Дагуур-Монголын хээрийн провинцийн Дорнод Монголын хээрийн тойрогт Академич Н.Өлзийхутагийн ангиллаар Дорнод говийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна.



Зураг 26. Монгол орны ургамал – газарзүйн мужлал

Олон нуурын хөндийн цөлөрхөг хээрийн тойрогт Хангайн нуруу болон Говь Алтай, Монгол Алтайн нурууны хоорондох тавиун хотгор, Онгийн голоос Завхан гол хүртэлх хөндийг энд хамаарна. Говь ба Хангайн ургамлын аймгаас гаралтай цөлөрхөг хээр, хээрийн бүсийн төлөөлөгчид зонхилсон, нийт 481 зүйл ургамалтай ба зөвхөн энд ургадаг Нарийннавчит гиш (*Vicia angustifolia*), Гоохгор сухай (*Tamarix elongata*) гэх 2 зүйл бий.

Монгол орны газрын гадарга, уур амьсгалын онцлогтой зохицсон ургамалжилтын дараах 6 бүс, бүслүүр бий болжээ. Үүнд:

1. Өндөр уул буюу тагийн бүслүүр
2. Уулын тайгын бүслүүр
3. Уулын ойт хээрийн бүслүүр
4. Хуурай хээрийн бүс
5. Цөлөрхөг хээрийн бүс
6. Цөлийн бүс

Хээрийн бүс: монголын хээр, Төв Азийн цөлийн зааг нэлээд эрт үүсэж бий болсон, биеэ даасан үүсэлтэй, бүсэд ургадаг зонхилогч ургамалуудтай байдгаараа онцлог бөгөөд тэр нь Их нууруудын хотгор Олон нуурын хөндий, Дорноговийн нам өндөрлөг, Говь Алтайн нурууг хамаарна. Цөлөрхөг хээрийн бүсэд жилдээ 100-125мм тунадас унадаг, ургах хугацаа 170-190 хоног үргэлжилдэг. Цөлөрхөг хээрт жижиг үетнүүдээс гадна гуравласан боролзой, төлөгчдүү боролзой, таана орог тэсэг, бор бударгана, навчгүй баглуур, нохой шээрэнгэ, улаан харанга, хамхуул, монгол догор, данхар хависхана, шарилж, шаваг элбэг ургана.



Судалгааны талбайн онцлог. Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний ойр орчмын нутаг нь цөлөрхөг хээрийн хуурай уур амьсгалтай. Ургамал газарзүйн хувьд цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагдах бөгөөд дөрвөн улирлын ялгаа ихтэй, агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага ордог зэрэг эх газрын эрс тэс уур амьсгалтай. Төслийн талбай нь газрын гадаргын ихэнх хэсгийг нам толгод (58%) болон тэгш өндөрлөг (29%) бүрдүүлнэ. Тус бүс нутаг нь Монгол орны хөрс - газарзүйн мужлалаар говийн хөрсний их мужид багтаж Их нууруудын хотгорын мужийн, Өмнөговийн тойрогт хамаарагддаг. Говийн заримдаг цөлийн бор хөрс зонхилон тархах бөгөөд нам хотгор газраар сайрхаг хөрс тархана. Говийн их мужийн 50% орчим нь говийн бор хөрстэй. (Д. Доржготов, 1974)

Мөн бүс нутаг нь Монгол орны ургамал - газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагддаг. Уг тойрог баруунаасаа Говь Алтайн уулын цөлөрхөг хээрийн урд талаасаа Алашаа говийн, зүүн хэсгээрээ Дорнод монголын хойд талаасаа Дундад халхын тойргуудтай хил залгадаг онцлогтой. (Н.Өлзийхутаг, 1985).

6.3. Ургамлын зүйлийн бүрдэл

Судалгааны дүнд нийт 22 овог 51 төрөлд хамаарагдах 70 зүйл дээд ургамал бүртгэгдсэн. Бүртгэгдсэн нийт ургамлыг амьдралын хэлбэр ангилбал олон наст өвс (50%), сөөг, заримдаг сөөг (20%) зонхилох хувийг эзэлж байна. Мөн ургамлуудыг экологийн бүлгээр буюу амьдрах орчиндоо хандах байдлаар нь ангилан авч үзвэл хуурайсаг буюу ганд тэсвэртэй (ксерофит) ургамлын зүйлүүд ихэнх хувийг нь бүрдүүлж байна Үүнээс үзэхэд төслийн талбай болон түүний ойр орчмын нутаг дэвсгэрт хуурайсаг, хуурайсаг-чулуусаг, элссэг сөөг, заримдаг сөөг ургамлууд цөлөрхөг хээрийн бүсийн онцлогт зохилдон тархжээ. Одоохондоо нэг ба хоёр наст хөл газрын ургамал цөөн тоогоор дайралдаж байна. Түүнчлэн бүртгэгдсэн ургамлын зүйлүүдийн дотор цөлөрхөг хээрийн бүсийн бэлчээрийн хэв шинжийг бүрдүүлэгч бэлчээр, тэжээлийн өндөр ач холбогдолтой ургамлууд олноор тохиолдож байна. Үүнд: *Allium polyrrhizum*, *Stipa gobica*, *Stipa krylovii*, *Stipa glareosa*, *Anabasis brevifolia*, *Brachanthemum gobicum* зэрэг 42 зүйл ургамлыг нэрлэж болно.

Ургамалжилтын хувьд авч үзвэл Говь цөлийн баглуур - таанат, хялгана - таанат хээрийн шинжийг бүрдүүлэгч Говийн хялгана (*Stipa gobica*) цөлөрхөг хээр, цөл, тэгш тал, уул толгодын хормой, үйрмэг чулуутай хажуу ба асга, хайрга чулуутай цөлд ургана. Тэжээлийн ач холбогдол өндөртэй цөлөрхөг хээрийн шинжийг бүрдүүлэгч ургамал. Ахар навчит баглуур *Anabasis brevifolia* Цөлөрхөг хээр, цөл, тэгш тал, уул толгодын хормой, сайр-чулуурхаг хажуу, хуурай марз, уулын дунд бүс хүртэлх хад, хайрга чулуутай газар ургана.. Залуу найлзуур нь хортой боловч малчдын аман яриагаар тэмээний үндсэн тэжээлийн болон цөлийн бүсийн зонхилогч ургамлын нэг юм. *Stipa glareosa* Сайрын хялгана Цөлөрхөг хээр, цөлийн бүсэд тэгш тал, уулын чулуурхаг хажуу, хормой, хайргархаг бэлээр элсэрхэг болон чулуурхаг хөрстэй цөлд ургана. Дээр дурдсан зүйлүүд нь бэлчээр тэжээлийн зонхилох ургамлууд юм. Монгол бүйлээс (*Amygdalus mongolica*) цөлийн бүсийн хад асга, манхан элс, толгодын элсэрхэг - үйрмэг чулуут хажуу, чулуурхаг орой ирмэг, сайр жалгын ёроолд ургана. Үрэндээ өөх тос, уураг ихтэй, тэжээлийн ургамал юм. Үүнийг мөн эмийн болон гоёл чимэглэлд хэрэглэнэ. Говийн тост (*Brachanthemum gobicum*) цөлөрхөг хээр, цөлийн бүсэд сул элс, элсэрхэг хайргархаг цөлд ургадаг онцлогтой. Уг зүйл нь бэлчээр тэжээлийн зориулалтаар ашиглахаас гадна эфирийн тос агуулдаг цөлийн бүсийн зонхилогч ургамлын нэг.



Allium polyrrhizum



Stipa gobica

